



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/259

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалт, Монгол улсын 2008 оны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14-р зүйлийн 14.1, 14.2 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1, 26.1.1 заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал" батлах тухай 91 дүгээр тогтоолын 3 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар"-ыг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт, "Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам"-ын 2.1 дэх заалтад орсон багшаас бусад ажилтан (цэцэрлэгийн тогооч, туслах тогооч, гал тогооны туслах ажилтан, нярав, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны багш, тогооч, туслах тогооч, нярав)-ын үзлэг шинжилгээний зардлыг тухайн жилийн эрүүл мэндийн үйлчилгээний батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлэхийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг удирдлагаар ханган, аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газарт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсролын Ерөнхий газар (Т.Ням-Очир), Санхүү, хөрөнгө оруулалтын газар (О.Хуягцогт), Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар (Ж.Ганбаатар), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Ч.Энх-Амгалан) нарт тус тус үүрэг болгосугай.



Л.ЭНХ-АМГАЛАН

142210949



ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШИЙГ ЭРҮҮЛ МЭНДИЙН НЭМЭЛТ ҮЗЛЭГ, ОНОШИЛГООНД ХАМРУУЛАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн “Багшийн эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай” А/238, А/340 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг хамруулах нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалт”-д заасан нэмэлт үзлэг, оношилгоог зохион байгуулахад энэхүү зааврыг мөрдөнө.

1.2. Эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, тэгш хүртээмжтэй, хамт олны саналд тулгуурласан, үр дүнтэй байх зарчмыг баримтална.

1.3. “Эрүүл мэндийн үйлчилгээний зардал” гэж Монгол улсын Засгийн газрын 2022 оны “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” 91 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралт, 3.4.4-т заасныг ойлгоно.

1.4. “Сонгосон эрүүл мэндийн байгууллага” /цаашид “Эрүүл мэндийн байгууллага” гэх/ гэдэгт магадлан итгэмжлэгдсэн, дуран авиа, нян судлалын лаборатори бүхий, эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /ЭМДЕГ/-тай үзлэг, оношилгоо хийх гэрээ байгуулсан, тухайн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоо хийлгэхээр сонгосон төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг ойлгоно.

Хоёр. Эрүүл мэндийн үзлэг, оношилгоог зохион байгуулах

2.1. Цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал /цаашид “төсвийн шууд захирагч” гэх/ нь багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулахдаа энэхүү зааврын 1.3-т заасан эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг төлөвлөн, хэрэгжүүлнэ.

2.2. “Эрүүл мэндийн үйлчилгээний зардал”-ыг Монгол улсын Засгийн газрын 2022 оны “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” 91 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт /цэцэрлэгт нийт хувьсах зардлын 0.6 хувь/, хоёрдугаар хавсралт /ерөнхий боловсролын сургуульд нийт хувьсах зардлын 0.4 хувь/-д зааснаар тус тус тооцон тухайн жилийн эрүүл мэндийн үйлчилгээний батлагдсан төсөвт багтаан зохион байгуулна.

2.3. Төсвийн шууд захирагч нь энэхүү зааврын 2.6.2-т заасан эрүүл мэндийн байгууллагатай багшийн эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоог тухайн ондоо багтаан хийлгэх гэрээ байгуулна.

2.4. Хэрэв тухайн орон нутагт энэхүү зааврын 1.1-т заасан үзлэг, оношилгоог нэг эрүүл мэндийн байгууллага дангаараа хийх боломжгүй (тоног төхөөрөмж, оношилгооны аппарат байхгүй) тохиолдолд бусад эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан хэрэгжүүлж болно.

2.5. Төсвийн шууд захирагч нь "Эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоо"-нд хамруулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий (багш, ажилтны оролцоотой 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй) эрүүл мэндийн баг /цаашид "Эрүүл мэндийн баг" гэх/ байгуулна.

2.6. Энэхүү зааврын 2.5-д заасан Эрүүл мэндийн баг нь багш нарыг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулах хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

- 2.6.1. Эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамрагдах багш, ажилтны нэр, нас /*Дууны хөөчийн дурангийн шинжилгээг 40-өөс дээш насанд 3 жил тутам, Бамбайн дааврын шинжилгээг 2 жил тутам*/, багшаар ажилласан жилийг харгалзан эрүүл мэндийн үйлчилгээний батлагдсан төсөвтөө багтаан төлөвлөж, хуваарилах;
- 2.6.2. Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас гэрээний нөхцөл, үзлэг, оношилгооны үнийн санал, тухайн жилийн эрүүл мэндийн үйлчилгээний батлагдсан төсөв, энэхүү журмын 1.4-т заасан шаардлагыг харгалзан эрүүл мэндийн байгууллагыг сонгох;
- 2.6.3. Эрүүл мэндийн байгууллагад үзлэг, оношилгоонд хамрагдах багшийн нэр, нас, албан тушаалын мэдээллийг урьдчилан хүргүүлж, багш нарыг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамрагдах хуваарь гарган баталгаажуулж, хэрэгжүүлэх;
- 2.6.4. Багш нарт эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамрагдахад шаардлагатай зөвлөгөө, үзлэгийн хуваарийг танилцуулах;
- 2.6.5. Эрүүл мэндийн баг нь багшийн эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгооны чанар, гүйцэтгэлд хяналт тавих;
- 2.6.6. Эрүүл мэндийн байгууллагаас ирсэн багш нарын үзлэг, оношилгооны мэдээг боловсролын салбарын мэдээллийн системд оруулах, ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээг төсвийн шууд захирагчид танилцуулах.

2.7. Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага нь багшийн эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоог дараах байдлаар зохион байгуулна:

- 2.7.1. Төсвийн шууд захирагчтай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарт эрүүл мэндийн үзлэг, оношилгооны үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах;
- 2.7.2. Багшийн эрүүл мэндийн үзлэг, оношилгоог гэрээнд заасан хуваарийн дагуу, холбогдох эмнэлзүйн стандарт, аргачлал, зааврын шаардлагад нийцүүлэн багш нарт чирэгдэл үүсгэхгүй чанартай, зохион байгуулах;
- 2.7.3. Багшийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо дууссанаас хойш 7 хоногийн дотор үзлэг, оношилгооны мэдээг ЭМЯ-ны мэдээллийн санд бүртгэх;
- 2.7.4. Эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгооны хариу өөрчлөлттэй гарсан багшийг шаардлагатай тохиолдолд харьяаллын дагуу лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад холбогдох журмын дагуу илгээх;
- 2.7.5. Эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамрагдсан багш нарын эрүүл мэндийн үзлэг, оношилгооны ерөнхий мэдээллийг эмч болон эмнэлгийн удирдлага, эрх бүхий албан тушаалтан гарын үсэг, тэмдгээр

баталгаажуулан, холбогдох өвчлөлийн эрсдэлээс сэргийлэх, амьдралын зөв дадлыг хэвшүүлэх зөвлөмжийн хамт төсвийн шууд захирагчид хүргүүлэх;

2.7.6. Эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамрагдсан багш тус бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг битүүмжлэн зөвхөн өөрт нь хүргэх.

2.8. Эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг батлагдсан төсөвтөө багтаан дараах байдлаар зарцуулна:

2.8.1. Эрүүл мэндийн үзлэг, оношилгооны төлбөрийг энэхүү журмын 2.6.2-т заасны дагуу сонгосон эрүүл мэндийн байгууллагын албан ёсоор мөрдөж буй төлбөрийн дүнд үндэслэн тооцох;

2.8.2. Энэхүү журмын 2.6.6-д заасан эрүүл мэндийн багийн тайлан мэдээнд үндэслэн талууд гэрээг дүгнэн эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийг шилжүүлэх;

2.8.3. Эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийг хувь хүнд олгохгүй бөгөөд багшийн эрүүл мэндийн үзлэг, оношилгоо хийхээр гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагад үйлчилгээний төлбөрт зориулан шилжүүлэх.

Гурав. Бусад

3.1. Хэрэв багш хүндэтгэн үзэх шалтгаанаар эрүүл мэндийн нэмэлт үзлэг шинжилгээнд хамрагдаж чадаагүй бол эрүүл мэндийн байгууллагатай зөвшилцөн хугацааг хойшлуулж болно.

3.2. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хугацаандаа хамрагдаагүй багшийг эрүүл мэндийн үйлчилгээний зардлаас нөхөн хамруулахгүй.

3.3. Багшийн эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг 2021 оны Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйл, 12.2, 30.2 дахь заалтын хүрээнд талууд нууцлах бөгөөд энэ талаар гэрээнд тусгана.

3.4. Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Нийслэлийн боловсролын газар, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн “Эрүүл мэндийн үйлчилгээний зардал”-ын зарцуулалт, гүйцэтгэлд хяналт тавина.

3.5. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нь Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Журам батлах тухай” А/139 дүгээр тушаалаар баталсан “Хүн амын нас, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам”-ын хоёрдугаар хавсралт дахь Насанд хүрэгсдийн эрт илрүүлгийн товлол, давтамжид заасан цээжний рентген шинжилгээнд харьяа аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагад хамрагдаж, эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэгээ (үзлэг, оношилгоо давхар хийгдэж болзошгүй) хийлгэнэ.

3.6. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт, “Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам”-ын 2.1 дэх заалтад орсон багш бус ажилтны (цэцэрлэгийн тогооч, туслах тогооч, гал тогооны туслах ажилтан, нярав, ЕБС-ын 1-5 дугаар ангийн багш, дотуур байрны багш, тогооч, туслах тогооч, нярав)-ийн үзлэг шинжилгээний зардлыг Монгол улсын 2008 оны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14-р зүйлийн 14.1, 14.2 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1, 26.1.1 заалтад үндэслэн тухайн жилийн эрүүл мэндийн үйлчилгээний батлагдсан төсвөөс тооцон санхүүжүүлнэ.

Дөрөв. Хариуцлага

4.1. Энэхүү журмын 3.3-т заасан багшийн эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг нууцлах заалтыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

4.2. Энэхүү зааврыг хэрэгжүүлэхэд оролцогч талууд хамтран ажиллах бөгөөд үйл ажиллагаанд саад учруулах, худал мэдээлэл тараах, энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд буруутай байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---